



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Аялал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/748 дугаар захирамж, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын 378 жилийн ойг тохиолдуулан аялал жуулчлалын мэргэжлийг сонгон суралцаж буй их, дээд сургуулиудын оюутнуудыг хамруулсан хотын түүх, соёл, аялал жуулчлалын бүтээгдэхүүн таниулах, байгаль орчин хайрлан хамгаалах, үндэсний үйлдвэр аж ахуйн газруудын үйл ажиллагаатай танилцуулах аяллыг 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулахыг Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний хөгжил хариуцсан мэргэжилтэн Б.Ишдорж, Мэдээлэл сурталчилгааны төвийн менежер С.Баяржаргал нарт тус тус даалгасугай.

2. “Хотын аялал” зохион байгуулах ажилд шаардагдах төсвийг хавстралт ёсоор баталсугай.

3. “Хотын аялал” зохион байгуулах ажилд шаардагдах төсөв болох 3.750.000 /гурван сая долоон зуун тавин мянга/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Batsukh* Д.БАТСҮХ



1150500318

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 10 сарын 14  
өдрийн 01.8.5 дугаар тушаалын хавсралт



“ХОТЫН АЯЛАЛ”  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2017 оны 10 сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

| №        | Зардлын зүйл                | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ  |
|----------|-----------------------------|------------|----------|-----------|
| 1        | Автобусны түрээс            | 3          | 180 000  | 540 000   |
| 2        | Цэвэр ус                    | 137        | 500      | 68 500    |
| 3        | Зураг угаалгах              | 19         | 3 500    | 66 500    |
| 4        | Хөтөч тайлбарлагчийн зардал | 3          | 80 000   | 240 000   |
| 5        | Музей үзэх тасалбар         | 135        | 2500     | 337 500   |
| 6        | Чингисийн хүрээ тасалбар    | 135        | 5 000    | 675 000   |
| 7        | Өдрийн хоолны зардал        | 135        | 13 500   | 1 822 500 |
| Нийт дүн |                             |            |          | 3 750 000 |

--oo0oo--

ХЯНАСАН:  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТБААТАР

ТӨСӨВ ЗОХИОСОН:  
ДОТООДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖИЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ИШДОРЖ